Цар тахлын нөлөө ЖДҮҮ эрхлэгчдэд

/ Судалгаа /

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд Ковид-19 коронавирус болон цар тахлын эсрэг төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд хэрхэн нөлөөлж буй талаарх судалгааг авч нэгтгэлээ.Судалгаанд нийт 623 ЖДҮҮ эрхлэгчид оролцсон ба судалгааны асуулгын үр дүнг танилцуулж байна.

1. Таны нас?

146 responses




2. Таны хүйс?

146 responses




3. Таны боловсролын түвшин?

146 responses



4. Та ямар салбарт үйл ажиллагаа эрхэлдэг вэ?
145 responses




5. Та ямар хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлдэг вэ?
146 responses




6. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлсэн үү?
146 responses



7. Та хэдэн жил жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байна вэ?
141 responses




8. Танай байгууллага хэдэн ажилтантай вэ?
145 responses




9. Цар тахал гарч хөл хорионы дэглэм тогтоосноор танай байгууллагын үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байна вэ?
146 responses



10. Танай байгууллага хүний нөөцийн эрсдэлтэй энэ үед ажилчдынхаа цалинг хэрхэн өгч байгаа вэ?

146 responses




11. Та хэдий хэмжээний зээлтэй вэ? /сая төгрөгөөр/

139 responses




12. Та ямар байгууллагаас зээл авсан бэ?

139 responses



13. Таны авсан зээлийн жилийн хүү хэд вэ?
140 responses




14. Төрөөс коронавирусийн эсрэг үзүүлж буй бодлого арга хэмжээнүүд танд хэр өгөөжтэй байна вэ?
144 responses




15. Коронавирусийн цар тахал гарч хатуу хөл хорионы дэглэм тогтоосноор танай байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна уу?
146 responses



16. Танай байгууллагын үйл ажиллагаанд ямар хүндрэлүүд гарч байна вэ?
146 responses




17. Гарч буй хүндрэлүүдийг давахад нэмэлт санхүүжилт хэрэгтэй юу?
144 responses




18. Танд хэдэн төгрөгний санхүүжилт шаагдлагатай вэ? /сая төгрөгөөр/
142 responses



19. Нэмэлт санхүүжилт авахад танд тулгарч буй бэрхшээл юу вэ?

144 responses




20. Нэмэлт санхүүжилт авбал юунд зарцуулах вэ?

144 responses




21.Танай байгууллага “бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” буюу жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж бол орлого хэдэн хувиар буурсан бэ?

115 responses



22.Танай байгууллага “жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” буюу жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой ...йн нэгж бол орлого хэдэн хувиар буурсан бэ?
74 responses




23. Танай байгууллага “дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” буюу жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж бол орлого хэдэн хувиар буурсан бэ?
47 responses




24.Танай байгууллагын ажиллах цагийн хэлбэрт өөрчлөлт орсон уу?
140 responses



25. Цаашид ажлын байртай холбоотой ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?
143 responses




26. Ковид-19 коронавирусийн нөлөөлөлд өртсөн байгууллагуудад төрөөс ямар дэмжлэг үзүүлвэл зохих вэ?
146 responses




27. Танай байгууллага хэрэглэгчидээ хадгалах, хамгаалах өөр бусад арга замуудыг хэрэгжүүлсэн эсэх?
144 responses



# ДҮГНЭЛТ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Жижиг, дунд үйлдвэрийн газраас 2020 оны 11 дүгээр сарын 28-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-ний хооронд Улаанбаатар хот, орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн дунд коронавирусын цар тахал хэрхэн нөлөөлж буй талаарх судалгааг цахим хэлбэрээр явуулж нийт 623 ЖДҮҮ эрхлэгчид хамрагдлаа.

Судалгаанд хамрагдсан нийт ЖДҮҮ эрхлэгчдийн 22.6 хувь нь 26-35 настай, 34.9 хувь 36-45 настай, 31.5 хувь нь 46-55 настай хүмүүс байсан бөгөөд 62.3 хувь нь эрэгтэй, 37.7 хувь нь эмэгтэй хүмүүс хамрагдсан байна. Мөн үйл ажиллагааны чиглэл нь үйлдвэрлэл 51 хувь, үйлчилгээ 28.3 хувь, худалдаа 14.5 хувь ба хуулийн этгээдийн хэлбэр иргэн 19.2 хувь, компани 77.4 хувь, хоршоо, нөхөрлөл 4.4 хув, хамрагдлаа.

Судалгаанд оролцогсдын 71% нь 10-аас доош жил үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 75.9% нь 10 хүртэл ажилтантай “бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч” гэсэн ба 56% нь ЖДҮХСангаас зээл авсан зээлдэгчид хамрагдсан байна.

Цар тахал гарч хатуу хөл хорионы дэглэм тогтоосноор нийт судалгаанд оролцогсдын 98% нь үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна гэсэн бөгөөд тэдгээрийн 67 хувь нь үйл ажиллагаа зогссон гэсэн ба 20 хувь нь богиносгосон цагаар ажиллаж байгаа гэсэн байна. Мөн ажилчдынхаа цалинг хэрхэн өгч байгаа талаарх асуултад 13.7 хувь нь бүтнээр өгч байгаа гэсэн бөгөөд 57 хувь цалин олгох боломжгүй байна гэсэн байна. Цаашид ажлын байртай холбоотой ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа талаар тодруулахад 24.5 хувь нь ажлын байрны тоог хэвээр авч үлдэнэ гэсэн бөгөөд 17.5 хувь ажлын байрны тоог цөөлнө гэсэн байна. Харин 50-иас дээш хувь нь тодорхойгүй байна гэсэн хариулт өгсөн.

Төрөөс коронавирусын эсрэг үзүүлж буй бодлого, арга хэмжээнүүд хэр өгөөжтэй байна вэ гэсэн асуултад 79.2 хувь нь ямар ч нөлөөгүй, хэрэггүй гэсэн бөгөөд 20.8 хувь нь дэмжлэг болж байгаа гэсэн санал өгсөн бөгөөд хэрэгжүүлж буй бодлого арга хэмжээ бодит дэмжлэг болохгүй байгаа нь харагдаж байна.

Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ямар хүндрэлүүд гарч байгаа талаар асуухад 26 хувь нь зээлийн эргэн төлөлт хийх мөнгөгүй болсон, 24.7 хувь нь ажилчдын цалингийн эх үүсвэргүй , 22.6 хувь нь эргэлтийн хөрөнгөгүй болсон гэх зэрэг санхүүгийн хүндрэлүүд тулгарч байна гэж хариулсан байна.Үүсээд буй хүндрэлийг давахад хэдэн төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай эсэхэд 40.8 хувь нь 100.0 сая төгрөг хүртэл, 29.6 хувь 50.0 сая төгрөг хүртэл, 19.6 хувь 300.0 сая төгрөг хүртэл гэсэн байна. Мөн нэмэлт санхүүжилт авахад ямар бэрхшээл байгаа тулгарч буй талаарх асуултад 35 хувь нь зээлтэй учир зээл олгогдох боломжгүй гэсэн ба 22.9 нь барьцаа хөрөнгө хангалтгүй гэсэн байна.

Цар тахлын нөлөөлөлд өртсөн байгууллагуудад төрөөс ямар дэмжлэг үзүүлбэл зохих талаар 49.3 хувь нь хөнгөлөлттэй зээл олгох гэсэн бөгөөд 21.9 нь зээлийн төлбөр, хүү төлөх хугацааг хойшлуулах гэсэн ба 14.4 хувь нь татвар /НӨАТ/-ийн хөнгөлөлт, чөлөөлөлт гэсэн байна.

Иймд тус судалгааны үр дүнгээс харахад ЖДҮҮ эрхлэгчдэд коронавирусын цар тахлын нөлөөллийн улмаас ихээхэн санхүүгийн хүндрэл учирч буй бөгөөд дийлэнх хувьд нь төрөөс үзүүлж буй бодлого, арга хэмжээ нь бодитой дэмжлэг болохгүй байна гэсэн байна. Иймээс цаашид ажлын байр, хэрэглэгч, үйлчлүүлэгчдээ хадгалан үлдэж хэвийн үйл ажиллагааны горимд шилжих хүртэл бодитой санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгаа нь харагдаж байна.